



**САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ ХОРОО**
FINANCIAL REGULATORY COMMISSION
OF MONGOLIA

**ДААТГАЛЫН САЛБАРЫН 2017 ОНЫ 2 ДУГААР УЛИРЛЫН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТАНИЛЦУУЛГА**

УЛААНБААТАР ХОТ

Агуулга

1.ДААТГАЛЫН САЛБАРЫН ҮЗҮҮЛЭЛТ.....	2
1.1.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ.....	2
1.2.ДААТГАГЧИЙН ХӨРӨНГӨ.....	3
1.3.ДААТГАГЧИЙН ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ.....	4
1.4.ДААТГАЛЫН ХУРААМЖ.....	5
1.5.ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР.....	8
1.6.ДААТГАЛЫН НӨӨЦ САН.....	9
1.7.ДААТГАЛЫН ХОХИРЛЫН ХАРЬЦАА.....	10
1.8.ДААТГАГЧИЙН АШИГТ АЖИЛЛАГАА.....	12
1.9.ДАВХАР ДААТГАЛ.....	13
2.ЕРДИЙН ДААТГАЛ.....	13
2.1.ЕРДИЙН ДААТГАГЧИЙН НИЙТ ХӨРӨНГӨ.....	13
2.3.ЕРДИЙН ДААТГАЛЫН ХУРААМЖ.....	14
2.4.ЕРДИЙН ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР.....	15
2.5.ЕРДИЙН ДААТГАЛЫН ХОХИРЛЫН ХАРЬЦАА, АШИГТ АЖИЛЛАГАА.....	15
3.УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛ.....	17
3.1.УРТ ХУГАЦААНЫ ДААТГАГЧИЙН ХӨРӨНГӨ.....	17
3.2.УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛЫН ХУРААМЖ, НӨХӨН ТӨЛБӨР.....	17
3.3.УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛЫН ДАВХАР ДААТГАЛ.....	18
3.4.УРТ ХУГАЦААНЫ ДААТГАГЧИЙН НӨӨЦ САН, АШИГТ АЖИЛЛАГАА.....	18
4.АЛБАН ЖУРМЫН ДААТГАЛ.....	19
5.ДААТГАЛЫН МЭРГЭЖЛИЙН ОРОЛЦОГЧ.....	20
5.1.ДААТГАЛЫН ЗУУЧЛАГЧ.....	20
5.2.ДААТГАЛЫН ХОХИРОЛ ҮНЭЛЭГЧ.....	22
6.ДААТГАЛЫН САЛБАРТ ИРСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ.....	23

1.ДААТГАЛЫН САЛБАРЫН ҮЗҮҮЛЭЛТ

1.1.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

2017 оны 2 дугаар улирлын байдлаар ердийн даатгалын 15, урт хугацааны даатгалын 1, давхар даатгалын 1, даатгалын зуучлагч 40, даатгалын хохирол үнэлэгч 31 компани даатгалын зах зээлд үйл ажиллагаа явуулж байна. Мөн даатгалын компанийн 231 салбар, 11 төлөөлөгчийн газар, даатгалын зуучлагч компанийн 209 салбар, даатгалын хохирол үнэлэгч компанийн 50 салбар, 3 төлөөлөгчийн газар Хорооноос олгосон зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаагаа явуулж байна.

Хүснэгт-1

Даатгалын зах зээл дээрх тусгай зөвшөөрөл, эрх эзэмшигчдийн тоо

№		2013	2014	2015	2016	2017.II
1	Ердийн даатгалын компани	16	16	15	15	15
2	Урт хугацааны даатгалын компани	1	1	1	1	1
3	Давхар даатгалын компани			1	1	1
4	Даатгалын төлөөлөгч	3187	3260	3340	3091	3095
5	Даатгалын зуучлагч	20	30	37	40	40
6	Даатгалын хохирол үнэлэгч	14	20	27	31	31
7	Актуарч	15	15	15	15	18
8	Даатгалын үйл ажиллагаанд аудит хийх эрх бүхий аудитын компани				42	42
9	Аудитор				126	126
	БҮГД	3253	3342	3436	3362	3369

Хүснэгт-2

Даатгалын компани, даатгалын мэргэжлийн оролцогч компаниудын салбарын тоо

№		2013	2014	2015	2016	2017.II
1	Даатгалын компанийн салбар, төлөөлөгчийн газар	251	254	258	252	231
2	Даатгалын зуучлагч компанийн салбар	64	135	171	208	209
3	Даатгалын хохирол үнэлэгч компанийн салбар, төлөөлөгчийн газар	8	42	52	52	53
	БҮГД	323	431	481	513	493


2017 оны 2 дугаар улиралд: Хорооны 2017 оны 6 дугаар сарын 07-ны өдрийн 112 дугаар тогтоолоор “Голд стандарт эстимэйт” ХХК-д даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгосон. Хорооны 2017 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн 100 дугаар тогтоолоор “Соёмбо Ай Би” ХХК-ийн даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон.

1.2.ДААТГАГЧИЙН ХӨРӨНГӨ

Тайлант хугацаанд даатгалын компаниудын нийт хөрөнгийн хэмжээ 249.4 тэрбум төгрөг байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 48.1 тэрбум төгрөгөөр буюу 23.8 хувиар өссөн байна.

Дүрслэл-1


Давхар даатгалын болон даатгалын компаниудын нийт хөрөнгө, түүний өсөлт



Даатгалын компаниудын нийт хөрөнгийн салбарын хэмжээнд эзлэх хувийг авч үзвэл ердийн даатгалын компаниудын хөрөнгө 80.5 хувь, давхар даатгалын компанийн хөрөнгө 16.4 хувь, урт хугацааны даатгалын компанийн хөрөнгө 3.0 хувийг тус тус эзэлж байна. Ердийн, урт хугацааны болон давхар даатгалын компаниудын хөрөнгө, салбарын нийт хөрөнгөд эзлэх хувийг дараах дүрслэл болон хүснэгтээр дэлгэрэнгүй харуулав.

Дүрслэл-2

Салбарын хэмжээнд нийт хөрөнгөд эзлэх хувь



Даатгалын компаниудын нийт хөрөнгө


Даатгалын компани	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		Өсөлт/бууралт
	2016.06.30	2017.06.30	
Ард даатгал	9,555,250,745.3	10,466,530,186.7	9.5%
Бодь даатгал	15,363,327,763.5	23,661,842,956.0	54.0%
Ган зам даатгал	5,895,813,590.0	6,742,987,871.1	14.4%
Гэр даатгал	5,193,357,144.5	6,046,031,876.9	16.4%
Мандал женерал даатгал	13,559,636,383.8	22,818,068,902.8	68.3%
Миг даатгал	11,936,604,674.6	14,431,764,431.1	20.9%
Монгол даатгал	32,160,373,026.9	37,455,687,985.1	16.5%
Монре даатгал	6,281,369,343.2	6,953,013,474.4	10.7%
Мөнх даатгал	4,317,785,060.0	4,486,319,750.0	3.9%
Номин даатгал	9,528,403,130.9	11,014,429,239.4	15.6%
Нэйшнл лайф даатгал	7,356,336,031.1	7,514,182,368.6	2.1%
Практикал даатгал	10,852,677,805.1	12,322,596,040.7	13.5%
Соёмбо даатгал	9,614,949,060.1	10,529,331,233.8	9.5%
Тэнгэр даатгал	14,561,387,722.4	19,559,196,631.0	34.3%
Улаанбаатар хотын даатгал	5,557,344,068.4	5,644,829,563.3	1.6%
Хаан даатгал	7,429,651,082.9	8,779,485,141.0	18.2%
Хөдөө аж ахуйн давхар даатгал	32,231,477,751.1	41,021,281,120.8	27.3%
Нийт	201,395,744,384.0	249,447,578,773.3	23.9%

1.3.ДААТГАГЧИЙН ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ

Даатгалын компаниудын өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад нөөц сан 12.3 тэрбум төгрөгөөр, өр төлбөр 24.4 тэрбум төгрөгөөр, эзэмшигчдийн өмч 11.3 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна. Сүүлийн 5 жилд даатгалын компаниудын өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн өсөх хандлагатай байгааг дараах дүрслэлээр харуулав.

Дүрслэл-3

Даатгалын компаниудын нийт өр төлбөр ба эзэмшигчдийн өмч /тэрбум төгрөг/



Эзэмшигчдийн өмчийн өсөлтийн шалтгаан нь Хорооны “Даатгалын компанийн дүрмийн сангийн доод хэмжээг шинэчлэн батлах” тухай 355 дугаар тогтоолын дагуу зарим нэр бүхий компаниудын дүрмийн сангийн хэмжээ нэмэгдсэнтэй холбоотой байна.

Даатгалын компаниудын өр төлбөр, нөөц сан болон эзэмшигчийн өмчийн өсөлт

Үзүүлэлтүүд	2016.И		2017.И		Өөрчлөлт	
	төгрөгөөр	эзлэх хувь	төгрөгөөр	эзлэх хувь	төгрөгөөр	хувиар
Өр төлбөрийн дүн	53.8	26.7%	78.2	31.4%	24.4	17.4%
Нөөц сангийн дүн	48.9	24.3%	61.2	24.5%	12.3	1.1%
Эздийн өмчийн дүн	98.7	49.0%	110.0	44.1%	11.3	-10.0%
Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн	201.4	100%	249.4	100.0%	48.1	8.5%

Даатгалын компаниудын өр төлбөр ба эзэмшигчдийн өмч, нөөц сан /төгрөгөөр/

№	Даатгалын компани	Нөөц сангийн дүн	Өр төлбөрийн дүн	Эздийн өмч	Өр төлбөр ба эзэмшигчдийн өмч
1	Ард даатгал	1,572,597,036.3	6,298,853,883.9	4,167,676,302.8	10,466,530,186.7
2	Бодь даатгал	2,852,771,829.0	17,603,548,320.9	6,058,294,635.0	23,661,842,956.0
3	Ган зам даатгал	745,142,395.6	865,242,620.1	5,877,745,251.0	6,742,987,871.1
4	Гэр даатгал	849,473,327.0	1,349,634,590.1	4,696,397,286.7	6,046,031,876.9
5	Мандал даатгал	3,397,859,034.2	17,541,395,348.7	5,276,673,554.0	22,818,068,902.8
6	Миг даатгал	2,646,954,855.7	8,370,001,632.6	6,061,762,798.5	14,431,764,431.1
7	Монгол даатгал	10,543,510,883.6	27,675,678,868.3	9,780,009,116.8	37,455,687,985.1
8	Монре даатгал	730,310,748.1	2,788,013,363.9	4,165,000,110.4	6,953,013,474.4
9	Мөнх даатгал	407,312,472.0	558,590,712.0	3,927,729,038.0	4,486,319,750.0
10	Номин даатгал	4,342,424,027.1	6,571,360,730.8	4,443,068,508.5	11,014,429,239.4
11	Нэйшнл лайф даатгал	1,402,371,217.5	1,417,533,137.1	6,096,649,231.4	7,514,182,368.6
12	Практикал даатгал	3,005,357,641.3	7,216,882,569.4	5,105,713,471.3	12,322,596,040.7
13	Соёмбо даатгал	2,377,035,552.0	5,209,582,723.2	5,319,748,510.5	10,529,331,233.8
14	Тэнгэр даатгал	4,171,306,789.5	11,290,400,434.2	8,268,796,196.8	19,559,196,631.0
15	Улаанбаатар хотын даатгал	1,031,545,801.0	1,255,437,793.3	4,389,391,770.0	5,644,829,563.3
16	Хаан даатгал	1,621,826,313.3	3,781,474,666.9	4,998,010,474.1	8,779,485,141.0
17	Хөдөө аж ахуйн давхар даатгал	19,535,448,316.5	19,643,083,288.1	21,378,197,832.6	41,021,281,120.8
	Нийт дүн	61,233,248,240.3	139,436,714,684.2	110,010,864,089.0	249,447,578,773.3


1.4.ДААТГАЛЫН ХУРААМЖ

Даатгалын компаниуд 2017 оны 2 дугаар улиралд 690,199 иргэн, албан байгууллагатай даатгалын гэрээ байгуулж, 85.5 тэрбум төгрөгийн нийт хураамжийн орлого төвлөрүүлсний 98.0 хувь буюу 83.8 тэрбум төгрөгийг ердийн даатгалын компаниуд, 0.9 хувь буюу 0.7 тэрбум төгрөгийг урт хугацааны даатгалын компани, 1.2 хувь буюу 1.0 тэрбум төгрөгийг давхар даатгалын компани эзэлж байна. Даатгалын компаниудаас 5 тэрбум ба түүнээс дээш төгрөгийн даатгалын нийт хураамжийн орлого төвлөрүүлсэн 4 даатгалын компани байгаа бөгөөд зах зээлийн нийт хураамжийн орлогын 64.3 хувь нь ногдож байна. Тайлант улирлын даатгалын нийт

хураамжийн орлогыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 24.4 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд сүүлийн 5 жилийн дундаж өсөлтийн хувиас 17.3 хувиар өсөлттэй байна.

Дүрслэл-4

Даатгалын нийт хураамжийн орлого, давхар даатгалын хураамж /гэр бум төгрөг/



Дүрслэл-5

Даатгалын компаниудын төвлөрүүлсэн даатгалын хураамж /төгрөгөөр/

№	Даатгалын компани	Даатгалын хураамжийн нийт орлого	Даатгалын хураамжийн буцаалт	Давхар даатгалын хураамжийн зардал	Даатгалын хураамжийн цэвэр орлого
1	Ард даатгал	5,368,305,992.2	61,505,625.8	2,294,516,364.7	3,012,284,001.6
2	Бодь даатгал	21,038,568,396.1	186,357,060.3	14,800,645,666.2	6,051,565,669.6
3	Ган зам даатгал	109,297,650.2	73,509.0	-	109,224,141.2
4	Гэр даатгал	499,956,137.0	33,775,836.4	-	466,180,300.6
5	Мандал женерал даатгал	13,147,360,504.8	420,938,820.4	8,533,126,610.7	4,193,295,073.6
6	Миг даатгал	7,167,468,001.3	207,842,279.5	263,409,412.8	6,696,216,309.0
7	Монгол даатгал	15,472,527,448.9	223,016,364.9	5,433,935,699.8	9,815,575,384.2
8	Монре даатгал	2,178,042,912.3	91,904,429.4	66,224,304.6	2,019,914,178.2
9	Мөнх даатгал	413,288,649.0	-	-	413,288,649.0
10	Номин даатгал	2,507,381,163.0	86,909,338.7	168,965,078.0	2,251,506,746.2
11	Нэйшнл лайф даатгал	736,773,006.9	20,497.0	12,225,908.0	724,526,601.9
12	Практикал даатгал	4,359,698,690.1	98,724,896.1	199,028,980.0	4,061,944,813.8
13	Соёмбо даатгал	2,650,189,554.0	65,644,017.9	348,045,722.4	2,236,499,813.6
14	Тэнгэр даатгал	5,976,806,772.4	308,908,376.9	2,826,076,915.0	2,841,821,480.3
15	Улаанбаатар хотын даатгал	212,739,807.8	582,781.0	-	212,157,026.8
16	Хаан даатгал	2,689,414,888.0	50,881,560.8	93,144,252.0	2,545,389,075.1
17	Хөдөө аж ахуйн давхар даатгал	1,008,701,794.6	-	428,088,872.6	580,612,921.9
	Нийт	85,536,521,369.3	1,837,085,394.7	35,467,433,787.2	48,232,002,187.3


Тайлант хугацааны даатгалын хураамжийн нийт орлогын 71.2 хувь нь даатгалын 4 хэлбэрийн хураамжийн орлогоос бүрдэж байгаагийн 28.6 хувийг хөрөнгийн даатгал, 21.5 хувийг ЖХАЖД, 11.0 хувийг авто тээврийн хэрэгслийн даатгал, 10.1 хувийг гэнэтийн ослын даатгалын хураамж тус тус эзэлж байна.

Даатгалын хураамжийн нийт орлого / хэлбэрээр/

№	Даатгалын хэлбэр	Даатгалын хураамжийн нийт орлого		Өөрчлөлт/Бууралт
		2016.06.30	2017.06.30	
1	Гэнэтийн осол, эмчилгээний даатгал	5,568,120,009.7	8,663,648,035.8	55.6%
2	Хөрөнгийн даатгал	19,715,891,804.9	24,447,569,645.7	24.0%
3	Авто тээврийн хэрэгслийн даатгал	8,140,110,415.9	9,443,452,471.3	16.0%
4	Ачааны даатгал	625,204,415.0	637,252,723.4	1.9%
5	Барилга угсралтын даатгал	916,943,100.7	6,231,013,091.1	579.5%
6	Газар тариалангийн даатгал	-	-	0.0%
7	Мал амьтдын даатгал	309,668,107.0	236,506,840.0	-23.6%
8	Агаарын хөлгийн даатгал	1,353,943,377.3	1,073,564,387.0	-20.7%
9	Авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал	180,344,276.6	182,237,265.9	1.0%
10	Хариуцлагын даатгал	3,302,775,079.8	5,048,832,929.8	52.9%
11	Санхүүгийн даатгал	1,868,275,999.2	1,498,118,314.8	-19.8%
12	Зээлийн даатгал	360,029,540.3	1,163,788,877.3	223.2%
13	Итгэлцлийн даатгал	228,842,215.9	238,928,497.8	4.4%
14	Агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал	1,402,450,779.0	6,543,839,470.0	366.6%
15	Жолоочийн хариуцлагын даатгал	16,532,653,269.9	18,382,294,017.3	11.2%
16	Хугацаат амьдралын даатгал	57,545,789.1	131,997,769.7	129.4%
17	Хуримтлалын даатгал	49,065,783.0	62,986,743.0	28.4%
18	Тэтгэврийн даатгал	25,564,659.7	45,770,646.0	79.0%
19	Эрүүл мэндийн даатгал	462,793,529.8	496,017,848.2	7.2%
20	Мал амьтдын давхар даатгал	-	1,008,701,794.6	0.0%
Нийт дүн		61,100,222,153.5	85,536,521,369.3	40.0%

Дүрслэл-6

Даатгалын хураамжийн орлого төвлөрүүлэлт



1.5.ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР

Даатгалын тохиолдлын улмаас 2017 оны 2 дугаар улиралд нийт 25,036 даатгуулагчдад 17.3 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгожээ. Тайлант хугацаанд “Монгол даатгал” ХХК 3.2 тэрбум төгрөгийн, “Миг даатгал” ХХК 2.4 тэрбум төгрөгийн, “Мандал даатгал” ХХК 2.02 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгосон нь хамгийн өндөр бөгөөд нийт нөхөн төлбөрийн 44.2 хувийг эзэлж байна. Нийт салбарын хэмжээнд авч үзвэл нөхөн төлбөрийн хэмжээг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 36.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна.


Хүснэгт-8

Даатгалын компани	Нийт нөхөн төлбөрийн зардал		Өсөлт/ бууралт (хувиар)
	2016.06.30	2017.06.30	
Ард даатгал	1,186,189,299.4	983,269,729.2	-17.1%
Бодь даатгал	1,538,004,940.3	1,860,644,839.0	21.0%
Ган зам даатгал	17,406,720.0	39,271,178.0	125.6%
Гэр даатгал	45,947,538.0	163,399,199.0	255.6%
Мандал генерал даатгал	2,112,504,130.1	2,021,617,450.4	-4.3%
Миг даатгал	2,187,968,092.7	2,403,491,572.1	9.9%
Монгол даатгал	2,966,302,477.7	3,224,419,143.6	8.7%
Монре даатгал	886,706,733.4	1,007,760,783.3	13.7%
Мөнх даатгал	15,894,049.0	35,680,500.0	124.5%
Номин даатгал	629,162,210.0	699,915,698.9	11.2%
Нэйшнл лайф даатгал	449,718,134.6	664,499,909.6	47.8%
Практикал даатгал	1,526,037,874.1	1,643,648,152.6	7.7%
Соёмбо даатгал	1,278,860,438.6	963,532,994.1	-24.7%
Тэнгэр даатгал	1,071,725,126.1	985,990,835.4	-8.0%
Улаанбаатар хотын даатгал	105,138,095.0	57,074,567.0	-45.7%
Хаан даатгал	336,885,542.0	548,941,032.0	62.9%
Хөдөө аж ахуйн давхар даатгал	-	-	
Нийт дүн	16,354,451,400.9	17,303,157,584.2	36.8%

Даатгалын компаниудын нөхөн төлбөрийн хэмжээг сүүлийн 5 жилийн байдлаар доорх хүснэгтэд харуулав.

Дүрслэл -7

Даатгалын нөхөн төлбөр /тэрбум төгрөг/



Даатгалын компаниудын даатгалын нөхөн төлбөрийг даатгалын хэлбэрээр нь авч үзвэл жолоочийн хариуцлагын албан журмын даатгалаар 15,938 даатгуулагчид нийт 7.9 тэрбум төгрөгийн, авто тээврийн хэрэгслийн даатгалаар 6,072 даатгуулагчид 3.7 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг тус тус олгосон нь хамгийн өндөр дүнтэй нөхөн төлбөр олгосон даатгалын хэлбэрүүд байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад зээлийн даатгалын нөхөн төлбөр хамгийн их өсөлттэй буюу 6.6 дахин өссөн бол зээлийн даатгал болон автотээврийн хэрэгслийн даатгалын хэлбэрээр нөхөн төлбөр авсан даатгуулагчийн тоо 7.3 болон 2.6 дахин тус тус өссөн байна.

Хүснэгт-9


№	Даатгалын хэлбэр	2016.06.30		2017.06.30	
		Нөхөн төлбөр	Нөхөн төлбөр авсан гэрээний тоо	Нөхөн төлбөр	Нөхөн төлбөр авсан даатгуулагчийн тоо
1	Гэнэтийн осол, эмчилгээний даатгал	1,949,210,682.7	4,155	2,166,905,916.4	4,909
2	Хөрөнгийн даатгал	1,198,332,226.8	1,543	1,090,256,803.1	1,263
3	Авто тээврийн хэрэгслийн даатгал	3,756,621,094.0	6,219	3,740,798,744.0	6,072
4	Ачааны даатгал	70,604,533.6	12	47,147,801.0	11
5	Барилга угсралтын даатгал	5,706,880.0	222	0.0	0
6	Газар тариалангийн даатгал	0.0	0	0.0	0
7	Мал амьтдын даатгал	111,351,600.0	12	6,750,000.0	1
8	Авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал	38,181,311.0	16	16,718,053.4	57
9	Хариуцлагын даатгал	322,538,443.4	319	211,378,652.2	421
10	Санхүүгийн даатгал	1,074,068,380.8	328	1,150,440,499.6	350
11	Зээлийн даатгал	39,478,336.3	7	299,788,568.8	58
12	Агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал	6,852,686.4	4	4,107,263.4	4
13	Жолоочийн хариуцлагын даатгал	7,331,787,091.4	16,109	7,904,365,372.9	15,938
14	Хугацаат амьдралын даатгал	49,502,940.2	29	48,005,660.4	29
15	Хуримтлалын даатгал	40,664,213.3	35	28,702,290.0	7
16	Тэтгэврийн даатгал	5,599,925.7	12	6,055,257.0	0
17	Эрүүл мэндийн даатгал	353,951,055.4	1,094	581,736,702.2	1,029
	Нийт дүн	16,354,451,400.9	30,116	17,303,157,584.2	30,149

: Тайлант хугацаанд нөхөн төлбөр гараагүй даатгалын хэлбэрүүдийг дээрх хүснэгтэд оруулаагүй болно.

1.6.ДААТГАЛЫН НӨӨЦ САН

Даатгалын компаниудын нөөц сангийн хэмжээ 2017 оны 2 дугаар улиралд 61.2 тэрбум төгрөг болж өнгөрсөн оны мөн үеэс 68.9 хувиар өссөн байна. Даатгалын салбарын хэмжээнд “Монгол даатгал” ХХК, “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-иуд нийт нөөц сангийн 49.0 хувийг эзэлж байна. Сүүлийн 5 жилийн хугацааны даатгалын нөөц сангийн өсөлтийг дараах дүрслэлээр харуулав.


Даатгалын компаниудын нөөц сангийн хэмжээ болон өсөлтийн хувь



1.7.ДААТГАЛЫН ХОХИРЛЫН ХАРЬЦАА

Тайлант хугацаанд салбарын хэмжээнд нийт хохирлын харьцаа 22.8 хувьтай байна. Үүнд давхар даатгалд төлсөн хураамж болон давхар даатгагчаас төлсөн нөхөн төлбөрийг оруулж тооцсон болно. Мөн даатгалын компаниудын хувьд даатгалын цэвэр хураамжийн орлогоос тооцсон орлогод тооцсон хураамж, даатгагчаас олгосон нөхөн төлбөрийн харьцаагаар тооцоход салбарын хэмжээнд хохирлын харьцаа 38.9 хувьтай байна. Ердийн даатгалын компаниудын нийт хохирлын харьцааны хувьд ердийн даатгалын компаниудаас “Монре даатгал” ХХК-ийн хохирлын харьцаа 70.5 хувь байгаа нь хамгийн өндөр, “Бодь даатгал” ХХК хамгийн бага буюу 9.1 хувийн хохирлын харьцаатай бол “Нэйшнл лайф даатгал” ХХК-ын хохирлын харьцаа 90.2 хувь тус тус байна.

Даатгалын хохирлын харьцаа



Даатгалын компаниудын хохирлын харьцаа

№	Даатгалын компани	Орлогод тооцсон хураамж	Даатгагчаас олгосон нөхөн төлбөр	ХН харьцаа /цэвэр/
1	Ард даатгал	2,527,493,501.6	938,425,979.7	37.1%
2	Бодь даатгал	5,681,605,583.1	1,766,382,336.7	31.1%
3	Ган зам даатгал	270,107,964.6	39,271,178.0	14.5%
4	Гэр даатгал	275,929,978.8	163,399,199.0	59.2%
5	Мандал женерал даатгал	2,921,672,504.1	1,046,631,778.8	35.8%
6	Миг даатгал	5,210,033,245.0	2,388,446,180.4	45.8%
7	Монгол даатгал	7,924,940,685.4	2,871,480,282.3	36.2%
8	Монре даатгал	1,362,895,161.7	1,007,760,783.3	73.9%
9	Мөнх даатгал	381,680,481.0	35,680,500.0	9.3%
10	Номин даатгал	1,939,120,214.1	697,799,756.0	36.0%
11	Нэйшнл лайф даатгал	724,526,602.0	664,499,909.6	91.7%
12	Практикал даатгал	2,935,623,146.6	1,643,648,152.6	56.0%
13	Соёмбо даатгал	2,194,071,977.8	934,803,732.8	42.6%
14	Тэнгэр даатгал	3,339,972,703.9	980,967,622.9	29.4%
15	Улаанбаатар хотын даатгал	232,753,946.9	57,074,567.0	24.5%
16	Хаан даатгал	2,051,655,391.5	548,941,032.0	26.8%
17	Хөдөө аж ахуйн давхар даатгал	580,612,922.0	-	0.0%
	Нийт	40,554,696,010.0	15,785,212,991.1	38.9%

Давхар даатгалын хураамж, нөхөн төлбөрийг оруулж тооцсон хохирлын харьцаа

№	Даатгалын компани	Орлогод тооцсон хураамж+давхар даатгалын хураамж	Нийт нөхөн төлбөрийн зардал	ХН харьцаа /нийт/
1	Ард даатгал	4,822,009,866.3	983,269,729.2	20.4%
2	Бодь даатгал	20,482,251,249.3	1,860,644,839.0	9.1%
3	Ган зам даатгал	270,107,964.6	39,271,178.0	14.5%
4	Гэр даатгал	275,929,978.8	163,399,199.0	59.2%
5	Мандал женерал даатгал	11,454,799,114.8	2,021,617,450.4	17.6%
6	Миг даатгал	5,473,442,657.8	2,403,491,572.1	43.9%
7	Монгол даатгал	13,358,876,385.2	3,224,419,143.6	24.1%
8	Монре даатгал	1,429,119,466.4	1,007,760,783.3	70.5%
9	Мөнх даатгал	381,680,481.0	35,680,500.0	9.3%
10	Номин даатгал	2,108,085,292.2	699,915,698.9	33.2%
11	Нэйшнл лайф даатгал	736,752,510.0	664,499,909.6	90.2%
12	Практикал даатгал	3,134,652,126.6	1,643,648,152.6	52.4%
13	Соёмбо даатгал	2,542,117,700.3	963,532,994.1	37.9%
14	Тэнгэр даатгал	6,166,049,619.0	985,990,835.4	16.0%
15	Улаанбаатар хотын даатгал	232,753,946.9	57,074,567.0	24.5%
16	Хаан даатгал	2,144,799,643.6	548,941,032.0	25.6%
17	Хөдөө аж ахуйн давхар даатгал	1,008,701,794.6	.0	0.0%
	Нийт	76,022,129,797.3	17,303,157,584.2	22.8%

1.8.ДААТГАГЧИЙН АШИГТ АЖИЛЛАГАА


Даатгалын компаниудын цэвэр ашиг 2017 оны 2 дугаар улиралд 6.9 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 2.5 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Салбарын хэмжээнд цэвэр ашгийн өсөлтөд “Мөнх даатгал” ХХК, “Соёмбо даатгал” ХХК, “Миг даатгал” ХХК, “Ард даатгал” ХХК-иуд тайлант хугацаанд өндөр ашигтай ажилласан нь гол нөлөөлөгч хүчин зүйл болсон байна. Мөн тайлант хугацаанд “Нэйшнл лайф даатгал” ХХК-ийн хувьд 109.4 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж хуримтлагдсан алдагдал нь 282.2 сая төгрөгт хүрсэн байна.

Хүснэгт-12

№	Даатгалын компани	Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/		Өсөлт /бууралт/ хувиар
		2016.06.30	2017.06.30	
1	Ард даатгал	3,775,277.4	54,509,766.8	1343.9%
2	Бодь даатгал	232,196,094.1	460,056,901.8	98.1%
3	Ган зам даатгал	477,250,502.4	518,062,562.3	8.6%
4	Гэр даатгал	297,539,319.4	209,247,749.5	-29.7%
5	Мандал женерал даатгал	-494,020,299.2	378,307,175.7	-176.6%
6	Миг даатгал	197,841,093.8	596,706,095.1	201.6%
7	Монгол даатгал	840,383,738.9	202,112,557.1	-75.9%
8	Монре даатгал	303,532,882.0	-556,327,156.5	-283.3%
9	Мөнх даатгал	5,164,626.0	95,395,156.0	1747.1%
10	Номин даатгал	343,517,106.9	210,291,956.8	-38.8%
11	Нэйшнл лайф даатгал	78,256,999.4	109,442,949.7	39.9%
12	Практикал даатгал	73,112,191.8	81,751,625.2	11.8%
13	Соёмбо даатгал	33,801,793.2	325,248,044.2	862.2%
14	Тэнгэр даатгал	848,502,691.2	1,397,865,261.2	64.7%
15	Улаанбаатар хотын даатгал	84,695,404.8	6,411,290.7	-92.4%
16	Хаан даатгал	74,616,992.2	343,415,626.3	360.2%
17	Хөдөө аж ахуйн давхар даатгал	992,197,603.9	2,504,174,753.2	152.4%
	Нийт	4,392,364,018.2	6,936,672,315.1	57.9%

Дүрслэл-10

Тайлант үеийн цэвэр ашиг /тэрбум төгрөг/




1.9. ДАВХАР ДААТГАЛ

Тайлант хугацаанд “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК нь давхар даатгалын үйл ажиллагаа явуулж 1.01 тэрбум төгрөгийн давхар даатгалын хураамж төвлөрүүлж, 0.43 тэрбум төгрөгийг гадаадын давхар даатгагчид төлсөн байна. Харин ердийн болон урт хугацааны даатгалын компаниуд гадаадын давхар даатгагчид нийт 35.04 тэрбум төгрөгийн давхар даатгалын хураамжийг төлсөн байна. Энэ нь өмнөх оны мөн үеийн дүнгээс 15.43 тэрбум төгрөгөөр буюу 78.67 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Даатгалын компаниуд даатгалын нийт хураамжийн орлогоос 40.98 хувийг нь давхар даатгалд төлсөн байна. “Бодь даатгал” ХХК-ийн хувьд давхар даатгалд төлсөн хураамж нь нийт хураамжийнхаа 70.4 хувийг, “Мандал даатгал” ХХК-ийн хувьд 64.9 хувийг, “Тэнгэр даатгал” ХХК-ийн хувьд 47.3 хувь байгаа нь нийт салбарын үзүүлэлтэд ихээр нөлөөлсөн. Сүүлийн 5 жилийн байдлаар давхар даатгалын хураамж, нөхөн төлбөр, хураамжийн өсөлтийг дараах дүрслэлээр харуулав. Тайлант хугацаанд давхар даатгагчаас 1.5 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгосон нь нийт давхар даатгалын хураамжийн 4.3 хувийг эзэлж байна.

Дүрслэл-11

Давхар даатгалын хураамж, нөхөн төлбөр




2.ЕРДИЙН ДААТГАЛ

2017 оны 2 дугаар улирлын байдлаар 15 ердийн даатгалын компани, тэдгээрийн 242 салбар, төлөөлөгчийн газар Улаанбаатар хот, хөдөө орон нутагт үйл ажиллагаа явуулж байна.

2.1.ЕРДИЙН ДААТГАГЧИЙН НИЙТ ХӨРӨНГӨ

Ердийн даатгалын 15 компанийн нийт хөрөнгийн хэмжээ тайлант хугацаанд 200.9 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд өмнөх оны мөн үеэс 39.1 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. Сүүлийн 5 жилийн байдлаар ердийн даатгалын компаниудын нийт хөрөнгийн хэмжээ тогтмол өсөлттэй байгааг дүрслэл 12-д харуулав.


Ердийн даатгалын компаниудын нийт хөрөнгө /тэрбум.төг/



2.2.ЕРДИЙН ДААТГАГЧИЙН ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ

2017 оны 2 дугаар улирлын байдлаарх ердийн даатгалын компаниудын нийт өр төлбөр, эзэмшигчдийн өмч, нөөц сангийн харьцааг дараах дүрслэлээр харуулав. Даатгалын компаниудын өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн талаар 1.3 дахь хэсэгт дэлгэрэнгүй танилцуулсан.

Ердийн даатгалын компаниудын өр төлбөр, эзэмшигчдийн өмч ба нөөц сангийн харьцаа



2.3.ЕРДИЙН ДААТГАЛЫН ХУРААМЖ

Тайлант хугацаанд ердийн даатгалын компаниуд нийт 14 даатгалын хэлбэрээр 83.8 тэрбум төгрөгийн хураамж төвлөрүүлж, үүнээс давхар даатгалын хураамжид 35.0 тэрбум төгрөг төлж, 1.8 тэрбум төгрөгийн хураамжийг даатгуулагч нарт буцаан олгосноор 46.9 тэрбум төгрөгийн цэвэр хураамжийн орлоготойгоор тайлагнасан байна. Даатгалын компаниудын даатгалын хураамжийн орлогын талаар 1.4 дэх хэсэгт дэлгэрэнгүй танилцуулсан. Ердийн даатгалын нийт хураамжийн орлогыг даатгалын хэлбэрээр ангилж, дараах хүснэгтэд харуулав.

№	Даатгалын хэлбэр	Ердийн даатгалын хураамж	Нийт даатгалын хураамжид эзлэх хувь
1	Гэнэтийн осол, эмчилгээний даатгал	8,663,648,035.8	10.3%
2	Хөрөнгийн даатгал	24,447,569,645.7	29.2%
3	Авто тээврийн хэрэгслийн даатгал	9,443,452,471.3	11.3%
4	Ачааны даатгал	637,252,723.5	0.8%
5	Барилга угсралтын даатгал	6,231,013,091.2	7.4%
6	Мал амьтдын даатгал	236,506,840.0	0.3%
7	Агаарын хөлгийн даатгал	1,073,564,387.1	1.3%
8	Авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал	182,237,266.0	0.2%
9	Хариуцлагын даатгал	5,048,832,929.9	6.0%
10	Санхүүгийн даатгал	1,498,118,314.8	1.8%
11	Зээлийн даатгал	1,163,788,877.4	1.4%
12	Итгэлцлийн даатгал	238,928,497.8	0.3%
13	Агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал	6,543,839,470.0	7.8%
14	Жолоочийн хариуцлагын даатгал	18,382,294,017.3	21.9%
	Нийт дүн	83,791,046,567.7	100.0%

2.4.ЕРДИЙН ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР


Тайлант хугацаанд ердийн даатгалын компаниуд нийт 16.6 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг даатгуулагчид олгосноос 1.5 тэрбум төгрөгийг давхар даатгагч, 0.8 тэрбум төгрөгийг буруутай этгээд, 14.3 тэрбум төгрөгийг даатгагч нар тус тус төлсөн байна. Ердийн даатгалын компаниудын олгосон нөхөн төлбөр нь салбарын нийт нөхөн төлбөрийн 96.2 хувийг эзэлж байна. Даатгалын нөхөн төлбөрийн талаар 1.5 дахь хэсэгт дэлгэрэнгүй танилцуулсан.

2.5.ЕРДИЙН ДААТГАЛЫН КОМПАНИУДЫН АШИГТ АЖИЛЛАГАА

Ердийн даатгалын компаниудын 2017 оны 2 дугаар улирлын ашигт ажиллагааг 1.8 дахь хэсэгт дэлгэрэнгүй харуулсан бөгөөд тайлант хугацааны ашигт ажиллагааг өмнөх оны мөн үетэй харьцуулсан дүрслэлийг дараах байдлаар харуулав.

Дүрслэл-14

Ердийн даатгалын компаниудын ашигт ажиллагаа



2.6.ЕРДИЙН ДААТГАЛЫН НӨӨЦ САН, ДАВХАР ДААТГАЛ

Тайлант хугацаанд ердийн даатгалын компаниудын нөөц сан 40.3 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 5.5 тэрбум төгрөгөөр буюу 15.8 хувиар өссөн байна.

/төгрөгөөр/ Хүснэгт-14

Ердийн даатгалын төрөл	Даатгалын нөөц сан	2016.06.30	2017.06.30
Сайн дурын даатгал	Учирсан боловч мэдэгдээгүй хохирлын нөөц сан	6,212,675,878.6	5,625,782,880.2
	Мэдсэн боловч төлөөгүй хохирлын нөөц сан	1,216,349,972.0	3,759,281,809.3
	Учирч болзошгүй хохирлын нөөц сан	4,746,486,565.6	4,094,749,577.4
Албан журмын даатгал	Учирсан боловч мэдэгдээгүй хохирлын нөөц сан	1,787,499,282.8	2,648,561,330.3
	Мэдсэн боловч төлөөгүй хохирлын нөөц сан	309,170,271.6	1,055,791,615.7
	Учирч болзошгүй хохирлын нөөц сан	880,810,613.4	3,453,951,790.5
	Тусгай нөөц сан	19,657,309,703.0	19,657,309,703.0
ДҮН		34,810,302,286.9	40,295,428,706.3

Ердийн даатгагчид өөрийн хүлээж чадах эрсдэлээс давсан хэсгийг гадаадын давхар даатгагчид даатгуулахад тайлант хугацаанд 35.0 тэрбум төгрөгийг зарцуулсан нь өмнөх оны мөн үеэс 78.7 хувиар өссөн байна. Тайлант хугацаанд гадаадын давхар даатгагч нараас ердийн даатгалын 6 хэлбэрийн нөхөн төлбөрт 1.5 тэрбум төгрөг олгосон байна. Давхар даатгалын талаар 1.9 дэх хэсэгт дэлгэрэнгүй танилцуулсан.

/төгрөгөөр/ Хүснэгт-15


№	Даатгалын компани	Давхар даатгалын хураамжийн зардал		Өөрчлөлт
		2016.06.30	2017.06.30	
1	Ард даатгал	408,446,183.6	2,294,516,364.7	1,886,070,181.1
2	Бодь даатгал	10,072,829,348.7	14,800,645,666.2	4,727,816,317.5
3	Ган зам даатгал	-	-	-
4	Гэр даатгал	-	-	-
5	Мандал женерал даатгал	2,483,185,672.6	8,533,126,610.7	6,049,940,938.2
6	Миг даатгал	268,767,912.5	263,409,412.8	-5,358,499.7
7	Монгол даатгал	4,961,284,846.4	5,433,935,699.8	472,650,853.5
8	Монре даатгал	22,789,803.8	66,224,304.7	43,434,500.9
9	Мөнх даатгал	-	-	-
10	Номин даатгал	140,123,198.0	168,965,078.1	28,841,880.1
12	Практикал даатгал	434,277,730.6	199,028,980.0	-235,248,750.6
13	Соёмбо даатгал	236,437,555.0	348,045,722.4	111,608,167.5
14	Тэнгэр даатгал	506,956,168.4	2,826,076,915.1	2,319,120,746.7
15	Улаанбаатар хотын даатгал	-	-	-
16	Хаан даатгал	64,029,600.9	93,144,252.1	29,114,651.2
Нийт дүн		19,599,128,020.5	35,027,119,006.6	15,427,990,986.1

3. УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛ

3.1. УРТ ХУГАЦААНЫ ДААТГАГЧИЙН ХӨРӨНГӨ

“Нэйшнл лайф даатгал” ХХК нь 2008 оноос хойш урт хугацааны даатгалын үйл ажиллагаа явуулж байна. Тус компанийн хөрөнгийн хэмжээ сүүлийн 5 жилийн байдлаар тогтмол өссөн бөгөөд тайлант хугацаанд нийт хөрөнгийн хэмжээ 7.51 тэрбум төгрөгт болж өмнөх оны мөн үеийнхээс 2.1 хувиар өссөн байна.


Дүрслэл-15



3.2. УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛЫН ХУРААМЖ, НӨХӨН ТӨЛБӨР

“Нэйшнл лайф даатгал” ХХК-ийн даатгалын хураамжийн нийт орлого тайлант хугацаанд 736.8 сая төгрөг болж өмнөх оны мөн үеэс 23.8 сая төгрөгөөр өссөн байна. Тайлант хугацааны нийт нөхөн төлбөр 664.5 сая төгрөг бөгөөд урт хугацааны даатгагчийн хураамжийн нийт орлого, нийт нөхөн төлбөрийн харьцаа 90.2 хувьтай байна. Тайлант улирлын урт хугацааны даатгалын хураамжийн орлого, нөхөн төлбөр, тэдгээрийн харьцааг сүүлийн жилүүдтэй харьцуулав.

Дүрсэл-16




3.3. УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛЫН ДАВХАР ДААТГАЛ

“Нэйшнл лайф даатгал” ХХК нь давхар даатгалын хураамжид тайлант хугацаанд 12.2 сая төгрөгийг зарцуулсан байна. Урт хугацааны даатгалын сүүлийн 5 жилийн давхар даатгалын хураамжийг дүрслэлээр харуулав.

Дүрслэл-17

Урт хугацааны даатгалын компанийн давхар даатгалын хураамж /сая.төг/




3.4. УРТ ХУГАЦААНЫ ДААТГАГЧИЙН НӨӨЦ САН, АШИГТ АЖИЛЛАГАА

Тайлант хугацаанд урт хугацааны даатгагчийн нөөц сан 1,402.4 сая төгрөг болж өмнөх оны мөн үеэс 2.9 хувиар буурсан байна.


Дүрслэл-18

Урт хугацааны даатгагчийн нөөц сан /сая.төг/



“Нэйшнл лайф даатгал” ХХК нь 2008 оноос урт хугацааны даатгалын үйл ажиллагаа эрхэлж эхэлснээс хойш алдагдалтай ажиллаж байсан бол 2014 оноос эхлэн ашигтай ажиллаж, 2017 оны 2 дугаар улирлын байдлаар 109.4 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж, хуримтлагдсан алдагдал нь 282.2 сая төгрөг болж буурсан байна. Мөн цэвэр ашгийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 31.2 сая төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байгаа нь урт хугацааны даатгалын хураамжийн өсөлтөөс шалтгаалжээ. Урт хугацааны даатгагчийн ашигт ажиллагааг сүүлийн 5 жилийн байдлаар дараах дүрслэлээр харуулав.

Урт хугацааны даатгагчийн цэвэр ашиг, алдагдал / сая төгрөг/



4.АЛБАН ЖУРМЫН ДААТГАЛ


2017 оны 2 дугаар улирлын байдлаар ердийн даатгалын 15 компани жолоочийн хариуцлагын албан журмын даатгал /цаашид “жолоочийн хариуцлагын даатгал” гэх/-ын үйл ажиллагаа эрхэлж 18.4 тэрбум төгрөгийн нийт хураамжийн орлого төвлөрүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 1.8 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт-16

№	Даатгалын компани	Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын хураамжийн орлого		
		2016.06.30	2017.06.30	Өөрчлөлт
1	Ард даатгал	1,033,557,138.9	1,203,794,504.0	170,237,365.1
2	Бодь даатгал	1,942,704,636.7	2,252,189,684.0	309,485,047.2
3	Ган зам даатгал	18,052,174.0	17,932,948.0	-119,226.0
4	Гэр даатгал	110,049,073.0	423,263,692.0	313,214,619.0
5	Мандал женерал даатгал	1,628,266,970.0	1,056,287,642.0	-571,979,328.0
6	Миг даатгал	2,291,969,495.8	2,900,745,196.7	608,775,700.8
7	Монгол даатгал	3,513,891,595.7	3,492,245,789.6	-21,645,806.0
8	Монре даатгал	1,038,438,850.8	1,339,082,372.3	300,643,521.4
9	Мөнх даатгал	204,430,520.0	237,652,344.0	33,221,824.0
10	Номин даатгал	1,126,558,146.0	1,220,786,276.0	94,228,130.0
11	Практикал даатгал	1,385,355,986.0	1,506,968,945.2	121,612,959.2
12	Соёмбо даатгал	648,482,801.9	886,170,869.6	237,688,067.7
13	Тэнгэр даатгал	982,344,026.0	1,131,719,635.0	149,375,609.0
14	Улаанбаатар хотын даатгал	2,090,920.0	1,192,045.0	-898,875.0
15	Хаан даатгал	606,460,935.1	712,262,074.0	105,801,138.9
	Нийт	16,532,653,270.0	18,382,294,017.3	1,849,640,747.3


Тайлант хугацаанд даатгалын компаниуд жолоочийн хариуцлагын даатгалын 15,938 тохиолдолд нийт 7.9 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгосон байна. Албан журмын болон сайн дурын даатгалын нийт хураамжийн орлого, нийт нөхөн төлбөр, хохирол нөхөлтийн харьцааг доорх дүрслэлээр харьцуулж харуулав.

Даатгалын төрлөөр нийт хураамжийн орлого, нөхөн төлбөр /2017.11/



Сүүлийн 3 жилийн статистикаас харахад жолоочийн хариуцлагын даатгалын 1 гэрээ тутамд ногдож буй даатгалын тохиолдол болох магадлал нь дараах байдалтай байна.

ЖХАЖД-ын тохиолдол



5.ДААТГАЛЫН МЭРГЭЖЛИЙН ОРОЛЦОГЧ

5.1.ДААТГАЛЫН ЗУУЧЛАГЧ

2017 оны 2 дугаар улиралд даатгалын зуучлалын 41 компаниас 12 компани тайлангаа Фина санхүүгийн системд ирүүлээгүй бөгөөд нэгтгэлд орсон 29 компаниас 1 компани даатгалын зуучлалын үйл ажиллагаа эрхлээгүй байна. Тайлант хугацаанд 24 даатгалын зуучлагч компани, 8 банк даатгалын зуучлалын үйл ажиллагаа явуулж ердийн даатгалын 11, урт хугацааны даатгалын 1 хэлбэр зуучилж, 3.04 тэрбум төгрөгийн даатгалын зуучлалын шимтгэлийн орлого төвлөрүүлсэн нь салбарын нийт хураамжийн орлогын 3.6 хувийг бүрдүүлж байна.


№	Даатгалын зуучлалын компани	2016.06.30		2017.06.30	
		Зуучилсан даатгалын хураамжийн орлого	Даатгалын зуучлалын шимтгэлийн орлого	Зуучилсан даатгалын хураамжийн орлого	Даатгалын зуучлалын шимтгэлийн орлого
1	АМЕ	900,698,306.0	46,704,346.0	#N/A	#N/A
2	Ай Ай Би	3,694,782.0	988,068.0	5,938,833.0	1,169,762.0
3	Ар Эм Ай Би	#N/A	#N/A	#N/A	#N/A
4	Ариг банк	30,983,599.2	6,257,414.6	37,493,893.8	7,670,994.5
5	Арм интернэшнл	9,725,834.2	2,803,822.0	#N/A	#N/A
6	Асимон брокерс	1,658,157,336.1	129,553,143.2	439,768,410.9	48,564,229.0
7	Ачит ундарга	168,432,688.8	21,546,958.0	91,603,231.6	27,991,892.0
8	Бест солиушн			402,207,385.9	46,843,642.5
9	Ваясьню Солюшн	242,175,209.0	40,601,253.0	563,513,890.0	112,702,779.0
10	Голомт банк	772,747,689.3	107,767,979.4	1,548,851,611.6	223,835,727.7
11	Смарт брокерс	372,400,671.0	99,385,942.8	497,371,342.0	135,472,656.0
12	Дэвжих дэлгэрэх холдинг	48,060,396.0	7,209,059.0	36,579,997.0	6,399,289.0
13	Капитал банк	#N/A	#N/A	50,190,325.0	10,124,672.5
14	Ковер хилл	-	-	75,513,606.0	8,364,309.0
15	Лояалти солиушн	33,642,055.0	12,409,073.7	86,333,745.0	22,221,717.0
16	Мастер шийдэл	#N/A	#N/A	#N/A	#N/A
17	Монгол бичээч зууч	281,498,198.0	57,907,310.9	149,422,837.0	29,648,202.1
18	Монголиан интернэшнл брокерс	-	-	#N/A	#N/A
19	Монголиан иншуранс Брокерейж	9,328,450.0	2,292,017.5	#N/A	#N/A
20	Нэйшнл эженси	491,695,361.0	54,801,922.0	#N/A	#N/A
21	Ренессанс групп	#N/A	#N/A	8,520,485.8	3,907,503.3
22	Си эн эн икс	272,380,517.1	34,667,182.9	739,510,438.2	171,100,805.4
23	Соёомбо Ай Би	#N/A	#N/A	#N/A	#N/A
24	Сүрэг хараацай	1,371,262,723.0	306,256,543.8	1,524,741,144.0	319,848,482.1
25	Тод капитал	343,737,772.0	56,459,459.6	462,587,467.0	84,755,289.9
26	Төрийн банк	1,886,359,458.2	393,419,623.2	2,295,056,603.7	446,377,506.6
27	Тус брокерс	#N/A	#N/A	-	-
28	Түвшин ориент	-	-	#N/A	#N/A
29	Үндэсний хөрөнгө оруулалтын банк	1,393,909,649.1	336,716,559.3	1,372,849,737.5	291,833,524.3
30	Хаан банк	1,004,536,201.1	194,828,526.6	2,720,808,600.9	524,089,215.5
31	ХасБанк	341,439,461.9	68,287,892.4	759,849,887.2	131,117,045.6
32	Худалдаа хөгжлийн банк	1,724,885,366.2	257,161,984.8	2,279,451,806.0	369,260,942.4
33	Хүннү сиел	4,976,595.0	1,376,119.0	9,071,970.0	1,366,141.5
34	Цагаан гэрэлт	60,508,816.0	14,884,042.0	#N/A	#N/A
35	Эл Би брокерэж	270,722,131.0	38,142,206.9	#N/A	#N/A
36	Эм жи ай би	-	-	33,756,661.0	7,234,830.0
37	Эрсдэлийн шийдэл	371,402,500.0	89,074,294.7	#N/A	#N/A
38	Эс ай би эс	25,299,916.0	3,794,987.0	28,986,941.0	4,755,475.0
	Нийт	13,190,268,594.1	2,337,605,318.3	16,219,980,851.0	3,036,656,633.8

Тэмдэглэл:(-) -үйл ажиллагаа эрхлээгүй, (#N/A)-Фина системд тайлан ирүүлээгүй

2017 оны 2 дугаар улиралд даатгалын зуучлагч компани 1.04 тэрбум төгрөгийн, даатгалын зуучлагч банк 1.99 тэрбум төгрөгийн даатгалын зуучлалын шимтгэлийн орлого тайлагнасан бөгөөд нийт даатгалын зуучлалын шимтгэлийн орлого 3.04 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 29.9 хувиар өссөн байна.

Дүрслэл-22

Даатгалын зуучлалын орлого /тэрбум төгрөг/



5.2.ДААТГАЛЫН ХОХИРОЛ ҮНЭЛЭГЧ

Даатгалын хохирол үнэлэгч 31 компаниас 2017 оны 2 дугаар улиралд 21 компани үйл ажиллагаа явуулж тайлант хугацаанд нийт 7,017.4 сая төгрөгийн даатгалын хохирлын үнэлгээ бүхий 12,426 удаагийн даатгалын хохирлын үнэлгээ хийж, 357.5 сая төгрөгийн даатгалын хохирол үнэлгээний орлого төвлөрүүлжээ. Нийт дүнгээрээ даатгалын хохирол үнэлгээний орлого нь өмнөх оны мөн үеэс 13.0 хувиар өссөн байна.

/төгрөгөөр/ Хүснэгт-18

№	Хохирол үнэлэгч компани	2016.06.30			2017.06.30		
		Даатгалын хохирлын нийт үнэлгээ	Даатгалын хохирлыг үнэлсэн тоо	Даатгалын хохирол үнэлгээний орлого	Даатгалын хохирлын нийт үнэлгээ	Даатгалын хохирлыг үнэлсэн тоо	Даатгалын хохирол үнэлгээний орлого
1	Аа аперейзал	#N/A	#N/A	#N/A	#N/A	#N/A	#N/A
2	Арвижих эстимэйт	180,486,371.0	256	12,309,500.0	35,733,953.0	96	3,464,823.0
3	Арга билэг эстимэйт	75,512,191.0	168	4,471,000.0	-	-	-
4	Ашид билгүүн	906,403,472.0	3,693	133,095,346.1	1,568,619,511.0	3,583	101,598,922.0
5	Банхас	#N/A	#N/A	#N/A	222,043,939.0	484	7,215,000.0
6	Бэст эстимэйт	185,476,000.0	76	3,483,842.7	53,467,000.0	27	1,610,909.1
7	Вендо	2,230,362,948.4	2,437	59,709,636.4	1,888,042,142.0	1,404	36,849,156.4
8	Виннэрвэй	8,061,000.0	10	332,000.0	16,157,500.0	10	445,000.0
9	Гэрэгэ эстимэйт	479,256,636.0	947	22,050,000.0	579,662,084.0	1,274	47,938,783.6
10	Далайван аудит				-	-	-
11	Жи эй си си				#N/A	#N/A	#N/A
12	Итгэлт эстимэйт	144,070,086.0	219	5,265,452.0	258,830,815.0	230	8,714,091.3
13	Капитал эстимэйт	#N/A	#N/A	#N/A	#N/A	#N/A	#N/A
14	Кости эстимэйт	213,482,850.0	591	11,350,500.0	459,840,600.0	1,183	22,545,454.6
15	Лэндс	57,752,700.0	138	2,501,819.2	#N/A	#N/A	#N/A


Даатгалын салбарын 2017 оны 2 дугаар улирлын нэгдсэн танилцуулга

16	Мастер Үнэлгээ	194,347,535.0	250	13,336,363.6	441,940,425.0	733	22,682,272.7
17	Мега марз	-	-	-	10,810,000.0	34	752,727.3
18	Мөнх эстимэйт				4,700,000.0	5	4,700,000.0
19	Нарангэрэгэ				-	-	-
20	Сэлэнгэ эстимэйт	38,717,346.0	73	1,765,000.0	#N/A	#N/A	#N/A
21	Тэгшсонголт эстимэйт	11,410,448.0	19	624,000.0	5,558,900.0	20	299,090.8
22	Тэнцвэр эстимэйт	.0	24	1,084,872.7	469,304,000.0	348	11,598,500.0
23	Ухаашүрт консалтинг	369,239,793.0	1,365	12,736,727.0	628,974,550.0	1,605	20,188,182.0
24	Үнэлгээ консалтинг				40,208,050.0	117	2,830,500.0
25	Файн эстимэйт	-	-	-	#N/A	#N/A	#N/A
26	Фэйр валуэшн	205,488,074.0	567	13,225,000.0	224,364,668.0	553	13,703,000.0
27	Хас үнэлгээ	-	-	-	9,155,000.0	2	198,000.0
28	Хос стандарт	78,568,700.0	175	8,557,727.0	32,350,050.0	151	2,515,000.0
29	Хөрөнгө үнэлгээний төв	164,000.0	10	32,000.0	#N/A	#N/A	#N/A
30	Хөрөнгө эстимэйт	206,996,730.0	361	10,578,000.0	324,727,847.0	536	17,820,500.0
31	Тод үнэлгээ				1,714,000.0	31	29,877,503.0
	Нийт дүн	5,585,796,880.4	11,379	316,508,786.7	7,017,374,449.0	12,426	357,547,415.7

Тэмдэглэл:(-)-үйл ажиллагаа эрхлээгүй, (#N/A)-Фина системд тайлан ирүүлээгүй

Дүрслэл-24


Даатгалын хохирол үнэлгээний орлого /сая төгрөг/



6.ДААТГАЛЫН САЛБАРТ ИРСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ

Тайлант хугацаанд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас даатгалын үйл ажиллагаатай холбоотой нийт 65 өргөдөл Хороонд ирснээс 62 нь хуулийн хугацаанд шийдвэрлэгдсэн бөгөөд 3 гомдол хянагдах шатандаа байна.

Даатгалын салбарын өргөдөл гомдлын төрөл



Тайлант хугацааны даатгалын өргөдөл, гомдлыг бүтээгдэхүүний төрлүүдээр ангилан харуулбал Жолоочийн хариуцлагын албан журмын, тээврийн хэрэгслийн болон орон сууцны зээлдэгчийн гэнэтийн ослын даатгалын тохиолдлууд нийт гомдлын 90.6 хувийг эзэлж байна.

- Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын 23 тохиолдолд нөхөн төлбөр олгохоос татгалзсан 18, даатгалын хохирол үнэлгээтэй холбоотой 1, нөхөн төлбөрийг дутуу олгосон 4 маргаан байв.
- Тээврийн хэрэгслийн даатгалын 18 тохиолдолд нөхөн төлбөр олгохоос татгалзсаны хамгийн их нь даатгуулагч даатгалын гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй буюу Замын цагдаагийн газар, даатгагчид мэдэгдээгүй, хохирлын хэмжээг тодорхойлоогүй, даатгалын зүйлийг засварласан 6, даатгалын гэрээний дагуу нөхөн төлбөр олгохоос татгалзах нөхцөлтэй 4, даатгалын гэрээнд заасан эрсдэлээс өөр төрлийн эрсдэл учирсан 3, үлдсэн бусад шалтгаанаар нөхөн төлбөр олгохоос татгалзсан байв.
- Орон сууцны зээлдэгчийн гэнэтийн ослын 14 даатгалын тохиолдолд нөхөн төлбөр олгохоос татгалзсан хамгийн давтагдсан тохиолдол нь хөдөлмөрийн чадвараа 70 буюу түүнээс дээш хувиар алдсан үед даатгалын нөхөн төлбөрийг нэг жилд хамааруулан үндэслэлгүйгээр хасч олгосон 6, даатгуулсан хохирлын дүнг үндэслэлгүй бууруулж олгосон 4, үлдсэн нь бусад шалтгаанаар нөхөн төлбөр олгохоос татгалзсан байлаа.

Тайлант хугацаанд Хороонд ирүүлсэн өргөдөл, гомдлыг хуульд заасан хугацаанд урьдчилан шийдвэрлэж, нийт 66,553,473.0 (Жаран зургаан сая таван зуун тавин гурван мянга дөрвөн зуун далан гурван) төгрөгийн даатгалын нөхөн төлбөрийг олгуулсан байна.

Дүгнэвэл, даатгалын компани нөхөн төлбөр олгохоос татгалзсан тоо буурч байгаа бөгөөд татгалзсан тохиолдлын ихэнх нь эрх зүйн үндэслэлтэй байна.

-ДААТГАЛЫН ГАЗАР-